




САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: БНА-2026/001/НА-СТА-ТЕЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Баянхонгор хот 2026.04.20</p> 	<p>Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Аудитын менежер: М.Алтантуяа Утас: 70442424 Цахим хаяг: Altantuyam@audit.gov.mn Ахлах аудитор: Б.Нарангэрэл Утас: 99009293 Цахим хаяг: Narangerelb@audit.gov.mn Аудитор: Н.Батчимэг Утас: 88761199 Цахим хаяг: Batchimegn@audit.gov.mn Аудитор: Н.Бунчинсүрэн Утас: 99049866 Цахим хаяг: Bunchinsurenn@audit.gov.mn Аудитор: Г.Энхзул Утас: 99333147 Цахим хаяг: Enkhzulg@audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН	2
2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан.....	5
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	10
5. Аудитын илрүүлэлт.....	11
5.1. Албан шаардлага	12
5.2. Зөвлөмж.....	13
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	13

Товчилсон үгийн жагсаалт

АОУС,	Аудитын олон улсын стандарт
АДБОУС,	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ААНБ	Аж ахуй нэгж байгууллага
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
НББОУС,	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
СТОУС,	Санхүүгийн тайлангийн олон улсын стандарт
СХДАГ,	Санхүүгийн хяналт, дотоод аудитын газар
СТХС	Санхүү Төрийн сангийн хэлтэс
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
ОНӨҮГ	Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар
ОНӨААН	Орон нутгийн өмчит аж ахуйн нэгж
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар
ЖДҮ	Жижиг дунд үйлдвэрлэл
ЦТХХК	Цахилгаан түгээх хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХХС	Хоршоо хөгжүүлэх сан
ХХААХҮЯ	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
СНСЗЭТ	Сэтгэц нийгмийн сэргээн засах эмчилгээний тав
УТХО	Улсын төсвийн хөрөнгө оруулалт
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн тэргүүлэгчдийн хурал
ЭМТ	Эрүүл мэндийн төв

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584

Цахим шуудан: procurement.bayankhongor@audit.gov.mn

2026.04.20 № 2/172
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-д заасны дагуу Баянхонгор аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Баянхонгор аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Төсвийн ерөнхийлөн захирагч нь санхүүгийн нэгтгэсэн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Тайлант онд аймгийн ТЕЗ-ийн харьяаны төсөвт байгууллагуудын залруулагдаагүй зөрчлийн 31.5 хувь буюу 5,870.9 сая төгрөг нь санхүүгийн тайлагналын зөрчил (үүнээс материаллаг зөрчил нь 1.400.7 сая, материаллаг бус 4,470.2 сая) 68.5 хувь буюу 12,741.6 сая төгрөгийн зөрчил нь санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын зөрчил эзэлж байна.

/2026 он/1. бичиг хэрэгт тоот/2. ал-
албан тоот.docx

Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоо олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Тайланд онд аймгийн татварын орлогоор 44,503.4 сая төгрөг оруулахаар төлөвлөснөөс 43,127.5 сая төгрөг оруулж, 1,375.8 сая төгрөгийн орлогын төлөвлөгөө тасарсан байна.

Бусад асуудлын хэсэг

Аудитын дээд байгууллагын олон улсын стандартын дагуу аудитын мөрөөр хяналт тавих арга хэмжээ буюу өмнөх аудитаар өгсөн аудитын шийдвэрт дурдсан асуудлыг шалгагдагч байгууллага хэрхэн хэрэгжүүлж, шийдвэрлэснийг аудитор хянаж, үнэлэх үүрэг хүлээдэг.

Баянхонгор аймгийн ИТХ-ын хуралдааны 2026 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн 11/13 дугаар тогтоолоор аймгийн 2025 оны хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг 89 хувийн хэрэгжилттэй буюу "Үр дүн гарсан", Баянхонгор аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилтийг 94 хувийн хэрэгжилттэй буюу "Үр дүн гарсан", аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2025 оны хэрэгжилтийг 72 хувийн хэрэгжилттэй буюу "Үр дүн хүлээгдэж байгаа" гэж дүгнэсэн байна.

Баянхонгор аймгийн Шинэжинст сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа Эрдэнэ Монгол ХХК- нь 2025 оны 09 дүгээр сард үндсэн ордын уурхай ашиглалт орж хүдэр баяжуулах үйлдвэрлэл ашиглалтад орж алт, мөнгө олборлох, тушаах үйл ажиллагааг эхлүүлсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн нэгтгэсэн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн нэгтгэсэн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

3

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн нэгтгэсэн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Б.МӨНХБАТ



2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

(мянган төгрөгөөр)

№	Дансны нэр, төрөл	Тодруулга	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	1. ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		57,579,688.3	57,235,693.5
2	1.1.1 МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	31,206,723.0	26,058,215.1
3	1.1.3 АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	10,106,877.5	10,471,273.3
4	1.1.4 УРЬДЧИЛГАА	7а, 7б	832,951.5	749,077.3
5	1.1.5 БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	9,443,106.5	12,640,252.9
6	1.1.6 НӨӨЦИЙН БАРАА	9а	5,990,029.8	7,316,874.9
7	1.2 ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		135,891,211.9	152,881,201.9
8	1.2.2 ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	135,891,211.9	152,881,201.9
9	1.2.2.02 Биет хөрөнгө		123,339,155.5	139,551,632.0
10	1.2.2.03 Биет бус хөрөнгө	13	12,552,056.4	13,329,569.9
11	1 НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2		193,470,900.2	210,116,895.4
12	2.1 НИЙТ ӨР ТӨЛБӨР		15,863,598.0	13,630,945.7
13	2.1.1 БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		10,159,312.5	8,126,924.3
14	2.1.1.03 Өглөг		9,984,543.0	8,126,924.3
15	2.1.1.04 Урьдчилж орсон орлого	18а, 18б	174,769.5	0.0
16	2.1.2 УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		5,704,285.4	5,504,021.3
17	2.1.2.02 Урт хугацаат зээл	20а, 20б	5,704,285.4	5,504,021.3
18	2.2 ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		177,607,302.2	196,485,949.8
19	2.2.1 Засгийн газрын хувь оролцоо		177,607,302.2	196,485,949.8
20	2.2.1.01 Засгийн газрын оруулсан капитал		56,284,798.3	55,505,323.2
21	2.2.1.08 Хуримтлагдсан үр дүн		104,391,624.1	124,111,989.3
22	2.2.1.08.01 Өмнөх үеийн үр дүн		83,921,981.6	104,933,844.9
23	2.2.1.08.02 Тайлант үеийн үр дүн		20,469,642.5	19,178,144.3
24	2.2.1.09 Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		16,930,879.8	16,868,637.3
25	2 ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5		193,470,900.2	210,116,895.4

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

(мянган төгрөгөөр)

№	Дансны нэр, төрөл	Тодруулга	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН		161,175,174.3	161,107,890.6
2	1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО		38,202,045.9	43,127,512.9
3	1.1.1.03.1 Орлогын албан татвар		27,068,781.2	29,942,687.9
4	1.1.1.03.1.01 Хувь хүний орлогын албан татвар		27,150,780.5	30,329,216.6
5	1.1.1.03.1.02 Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт		-1,049,936.1	-1,668,189.1
6	1.1.1.03.1.04 ААН-ын орлогын албан татвар		967,936.8	1,281,660.4
7	1.1.1.03.3 Хөрөнгийн албан татвар		2,857,344.0	5,009,480.9

8	1.1.1.03.8 Бусад татвар, төлбөр, хураамж		8,275,920.7	8,175,344.1
9	1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	116,771,809.4	117,980,377.6
10	1.1.1.04.2 Хөрөнгийн орлого		0.0	310,712.6
11	1.1.1.04.3 Тусламжийн орлого		2,599,772.5	5,146,964.6
12	1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		6,201,319.1	0.0
13	1.1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	137,667,457.1	135,822,842.8
14	1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ		135,590,182.0	129,541,865.7
15	1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		132,890,339.3	127,319,086.8
16	1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		24,407,195.6	28,496,121.7
17	1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		2,991,722.0	3,511,332.2
18	1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		18,047,173.3	21,909,456.9
19	1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал		10,043,487.9	5,990,614.9
20	1.1.2.01.1.05 Нормативт зардал		130,072.6	604,918.2
21	1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал		1,276,682.8	1,795,172.6
22	1.1.2.01.1.07 Томилолт, зочны зардал		495,465.7	410,502.5
23	1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		34,678,200.8	15,887,327.0
24	1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал		40,820,338.7	48,713,640.8
25	1.1.2.01.3 ТАТААС		21,470.0	0.0
26	1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		2,678,372.7	2,222,778.8
27	1.1.2.02 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		2,077,275.1	6,280,977.1
28	1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		23,507,717.2	25,285,047.8
29	1.2.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН		0.0	15,180.0
30	1.2.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		3,038,074.7	6,122,083.5
31	1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)		-3,038,074.7	-6,106,903.5
32	1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)		20,469,642.5	19,178,144.4

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

(мянган төгрөгөөр)

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	1.1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	136,299,465.6	137,798,798.4
2	1.1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО	38,202,045.9	43,127,512.9
3	1.1.1.1.03.1 Орлогын албан татвар	27,069,221.2	29,942,687.9
4	1.1.1.1.03.1.02 Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-1,049,936.1	-1,668,189.1

5	1.1.1.1.03.1.04 ААН-ын орлогын албан татвар	967,936.8	1,281,660.4
6	1.1.1.1.03.3 Хөрөнгийн албан татвар	2,856,904.0	5,009,480.9
7	1.1.1.1.03.8 Бусад татвар, төлбөр, хураамж	8,275,920.7	8,175,344.1
8	1.1.1.1.03.8.01 Бусад нийтлэг төлбөр, хураамж	2,956,083.6	3,419,636.4
9	1.1.1.1.03.8.02 Газрын төлбөр	944,411.1	1,107,677.1
10	1.1.1.1.03.8.03 Байгалийн нөөц ашигласны төлбөр	3,871,879.7	3,531,645.8
11	1.1.1.1.03.8.04 Бусад татвар	503,546.3	116,384.8
12	1.1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	91,996,619.3	94,671,285.4
13	1.1.1.1.04.1 Нийтлэг татварын бус орлого	34,513,461.1	40,843,896.1
14	1.1.1.1.04.3 Тусламжийн орлого	2,510,653.4	6,922,492.9
15	1.1.1.1.04.4 Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	54,972,504.8	46,904,896.5
16	1.1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	6,100,800.4	0.0
17	1.1.1.2 НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	92,354,808.4	109,952,343.5
18	1.1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ	92,354,808.4	109,952,343.5
19	1.1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	89,599,291.4	107,883,151.9
20	1.1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	24,480,877.9	29,869,337.1
21	1.1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,995,907.3	3,509,144.6
22	1.1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	18,563,007.3	21,881,333.3
23	1.1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал	3,142,983.8	4,049,132.5
24	1.1.1.2.01.1.05 Нормативт зардал	111,818.1	622,500.7
25	1.1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал	1,441,515.9	1,868,856.7
26	1.1.1.2.01.1.07 Томилот, зочны зардал	476,655.8	408,991.4
27	1.1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,775,967.9	13,983,567.2
28	1.1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал	25,610,557.4	31,690,288.4
29	1.1.1.2.01.3 ТАТААС	21,470.0	0.0
30	1.1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,734,046.9	2,069,191.6
31	1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	43,944,657.2	27,846,454.9
32	1.1.2.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	28,362,488.5	31,416,170.3
33	1.1.2.2.01 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	28,362,488.5	31,416,170.3
34	1.1.2.2.01.1 Дотоод эх үүсвэрээр	28,362,488.5	31,416,170.3
35	1.1.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-28,362,488.5	-31,416,170.3
36	1.1.3.2 ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	0.0	397.2
37	1.1.3.4 САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	43,074.9	1,578,395.4
38	1.1.3 САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-43,074.9	-1,578,792.6
39	1.1 НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	15,539,093.8	-5,148,508.0
40	1.2 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	15,667,629.2	31,206,723.0
41	1 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	31,206,723.0	26,058,215.1

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(мянган төгрөгөөр)

Дансны код	Дансны нэр, төрөл	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	1.1.1.1.1.1 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	53,741,318.7	17,148,547.2	84,989,531.8	155,879,397.8
2	1.1.1.1.1.2 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	1,434,697.4	(185,474.1)	(1,067,550.2)	181,673.1
3	1.1.1.1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл	55,176,016.1	16,963,073.1	83,921,981.6	156,061,070.9
5	1.1.1.1.3 Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	1,108,782.2	(32,193.3)	-	1,076,588.8
9	1.1.1.1.7 Тайлант үеийн үр дүн	-	-	20,469,642.5	20,469,642.5
10	1.1.1.1 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	56,284,798.2	16,930,879.8	104,391,624.1	177,607,302.2
11	1.1.1 2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	56,284,798.2	16,930,879.8	104,391,624.1	177,607,302.2
12	1.1.2 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	542,220.8	542,220.8
13	1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл	56,284,798.2	16,930,879.8	104,933,844.9	178,149,523.0
14	1.2 Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	(59,762.5)	-	(59,762.5)
15	1.3 Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	(446,821.2)	(2,480.0)	-	(449,301.2)
17	1.5 Өмчид гарсан өөрчлөлт	(332,653.9)	-	-	(332,653.9)
19	1.7 Тайлант үеийн үр дүн	-	-	19,178,144.3	19,178,144.3
20	1 2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	55,505,323.2	16,868,637.3	124,111,989.3	196,485,949.8

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(мянган төгрөгөөр)

Дансны код	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	3.1.01.1 НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	119,118,538.7	105,877,167.1
11	3.1.01.1.1 Татварын орлого	44,503,354.8	43,127,512.9
110	3.1.01.1.1.1 Орлогын албан татвар	31,974,568.7	29,942,687.9
1100	3.1.01.1.1.1.1 Хувь хүний орлогын албан татвар	29,742,757.8	30,329,216.6
1101	3.1.01.1.1.1.2 Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(1,668,189.1)	(1,668,189.1)
1103	3.1.01.1.1.1.4 ААН-ын орлогын албан татвар	3,900,000.0	1,281,660.4
113	3.1.01.1.1.3 Хөрөнгийн албан татвар	5,782,516.5	5,009,480.9
118	3.1.01.1.1.8 Бусад татвар, төлбөр, хураамж	6,746,269.6	8,175,344.1
1180	3.1.01.1.1.8.1 Бусад нийтлэг төлбөр, хураамж	2,793,340.0	3,419,636.4
1181	3.1.01.1.1.8.2 Газрын төлбөр	936,000.0	1,107,677.1
1182	3.1.01.1.1.8.3 Байгалийн нөөц ашигласны төлбөр	3,016,929.6	3,531,645.8
1183	3.1.01.1.1.8.4 Бусад татвар	-	116,384.8

12	3.1.01.1.2 Татварын бус орлого	74,615,183.9	62,749,654.2
120	3.1.01.1.2.1 Нийтлэг татварын бус орлого	3,976,420.5	4,284,265.6
120002	3.1.01.1.2.1.2 Хүүгийн орлого	42,162.0	-
120003	3.1.01.1.2.1.3 Торгуулийн орлого	2,429,000.0	2,619,706.1
120004	3.1.01.1.2.1.4 Төсөв байгууллагын өөрийн орлого /үндсэн/	1,014,052.4	1,123,661.6
120010	3.1.01.1.2.1.5 Төсөв байгууллагын өөрийн орлого /туслах/	449,506.1	540,897.9
120006	3.1.01.1.2.1.7 Газрын тосны орлого	41,700.0	-
121	3.1.01.1.2.2 Хөрөнгийн орлого	450,895.0	282,587.0
122	3.1.01.1.2.3 Тусламжийн орлого	4,880,324.6	3,122,746.2
	Өмнөх оны төсвөөс санхүүжих	18,204,682.6	8,155,158.8
123	3.1.01.1.2.4 Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	47,102,861.2	46,904,896.5
II	3.1.01.2 НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	119,118,538.7	99,591,784.8
21	3.1.01.2.1 УРСГАЛ ЗАРДАЛ	81,032,746.2	73,723,447.9
210	3.1.01.2.1.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	77,107,228.9	69,994,298.3
2101	3.1.01.2.1.1.1 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	29,006,630.3	28,208,137.0
2102	3.1.01.2.1.1.2 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,599,102.6	3,487,481.2
2103	3.1.01.2.1.1.3 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	22,274,469.5	21,687,017.7
2104	3.1.01.2.1.1.4 Хангамж, бараа материалын зардал	3,795,620.9	3,382,463.4
2105	3.1.01.2.1.1.5 Нормативт зардал	747,457.3	576,368.2
2106	3.1.01.2.1.1.6 Эд хогшил, урсгал засварын зардал	2,655,551.4	2,430,255.4
2107	3.1.01.2.1.1.7 Томилот, зочны зардал	535,284.0	402,986.3
2108	3.1.01.2.1.1.8 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,075,194.0	2,721,143.0
2109	3.1.01.2.1.1.9 Бараа үйлчилгээний бусад зардал	10,417,918.9	7,098,446.3
213	3.1.01.2.1.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,925,517.3	3,729,149.5
2131	3.1.01.2.1.4.1 Засгийн газрын урсгал шилжүүлэг	2,495,484.1	2,483,736.1
2132	3.1.01.2.1.4.2 Бусад урсгал шилжүүлэг	1,430,033.2	1,245,413.5
22	3.1.01.2.2 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	38,085,792.5	25,868,336.9
221001	3.1.01.2.2.2 Их засвар	3,447,017.1	2,804,004.2
223001	3.1.01.2.2.4 Бусад хөрөнгө	34,638,775.4	23,064,332.8
8	3.1.01 ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	(18,204,682.6)	(1,869,776.5)
9	3.1 АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	18,204,682.6	1,869,776.5
7	3 Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	18,204,682.6	1,869,776.5

4	4 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	19,194,016.8
5	5 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	17,640,737.5
6	6 ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	1,765	1,764
61	6.1 БАЙГУУЛЛАГЫН ТОО	51	0
610001	6.1.01Төсвийн байгууллага	51	50
62	6.2 АЖИЛЛАГСАДЫН ТОО	857	899
620001	6.2.01 Удирдах ажилтан	219	29
620002	6.2.02 Гүйцэтгэх ажилтан	450	474
620003	6.2.03 Үйлчлэх ажилтан	129	137
620004	6.2.04 Гэрээт ажилтан	59	59
65	6.5 ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	857	815
650001	6.5.01 Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	324	284
650002	6.5.02 Төрийн тусгай албан хаагч (ТТ)	4	4
650009	6.5.09 Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	301	298
650010	6.5.10 Гэрээт ажилтан	61	59
650011	6.5.11 Улс төрийн албан хаагч (УТ)	167	170

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

(мянган төгрөгөөр)

Дансны код	Дансны нэр, төрөл	1. Тайлант он
1	1.1.1.1 НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	5,356,361.8
12	1.1.1.1.1 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	5,356,361.8
122	1.1.1.1.1.1 Тусламжийн орлого	5,356,361.8
1221	1.1.1.1.1.1.1 Хандив тусламж /дотоод/	5,356,361.8
12213	1.1.1.1.1.1.1.1 Нэмэлт санхүүжилтийн орлого	5,356,361.8
350011	1.1.1.1.1.1.1.1.1 Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	6,000.0
350013	1.1.1.1.1.1.1.1.3 ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	131,101.1
350014	1.1.1.1.1.1.1.1.4 Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,240,415.7
350015	1.1.1.1.1.1.1.1.5 Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	978,845.0
II	1.1.1.2 НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,742,051.2
21	1.1.1.2.1 УРСГАЛ ЗАРДАЛ	1,373,548.5
210	1.1.1.2.1.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,198,164.0
2101	1.1.1.2.1.1.1 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	70,460.9
210101	1.1.1.2.1.1.1.1 Үндсэн цалин	63,025.3
210102	1.1.1.2.1.1.1.2 Нэмэгдэл	6,489.2
210105	1.1.1.2.1.1.1.5 Гэрээт ажлын хөлс	946.4
2102	1.1.1.2.1.1.2 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	384.9
210201	1.1.1.2.1.1.2.1 Тэтгэврийн даатгал	384.9
2103	1.1.1.2.1.1.3 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	4,970.1

210301	1.1.1.2.1.1.3.1	Гэрэл, цахилгаан	1,071.3
210302	1.1.1.2.1.1.3.2	Түлш, халаалт	2,398.8
210304	1.1.1.2.1.1.3.4	Байрны түрээс	1,500.0
2104	1.1.1.2.1.1.4	Хангамж, бараа материалын зардал	18,114.6
210401	1.1.1.2.1.1.4.1	Бичиг хэрэг	442.5
210402	1.1.1.2.1.1.4.2	Тээвэр, шатахуун	10,948.4
210403	1.1.1.2.1.1.4.3	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,362.2
210404	1.1.1.2.1.1.4.4	Ном, хэвлэл	264.0
210406	1.1.1.2.1.1.4.6	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,097.5
2105	1.1.1.2.1.1.5	Нормативт зардал	16,145.2
210502	1.1.1.2.1.1.5.2	Хоол, хүнс	16,145.2
2106	1.1.1.2.1.1.6	Эд хогшил, урсгал засварын зардал	121,175.9
210601	1.1.1.2.1.1.6.1	Багаж, техник, хэрэгсэл	98,419.8
210604	1.1.1.2.1.1.6.4	Урсгал засвар	22,756.1
2108	1.1.1.2.1.1.8	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	333,588.6
210801	1.1.1.2.1.1.8.1	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	333,228.6
210806	1.1.1.2.1.1.8.6	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	360.0
2109	1.1.1.2.1.1.9	Бараа үйлчилгээний бусад зардал	633,323.9
210901	1.1.1.2.1.1.9.1	Бараа үйлчилгээний бусад зардал	631,291.7
210902	1.1.1.2.1.1.9.2	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,032.2
213	1.1.1.2.1.4	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	175,384.5
2132	1.1.1.2.1.4.2	Бусад урсгал шилжүүлэг	175,384.5
213208	1.1.1.2.1.4.2.7	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	172,714.5
213209	1.1.1.2.1.4.2.8	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,670.0
22	1.1.1.2.2	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	3,368,502.7
2200	1.1.1.2.2.1	Дотоод эх үүсвэрээр	3,368,502.7
220001	1.1.1.2.2.1.1	Барилга байгууламж	679,248.9
221001	1.1.1.2.2.1.2	Их засвар	2,486,082.6
223001	1.1.1.2.2.1.4	Бусад хөрөнгө	203,171.2
4	1.1.1	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	614,310.6
5	1.1	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-614,310.6
6	1	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	-614,310.6

5. Аудитын илрүүлэлт

Аудитаар 531.6 сая төгрөгийн 4 алдааг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.3-д “Төсвийн ерөнхийлөн захирагч нь төсвийн гүйцэтгэл болон жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу гаргана.”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-т "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална", 5.1.4-т "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.3-д “Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;”, Сангийн сайдын 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн Газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан тодруулга, бэлтгэх журам”-тай нийцэхгүй, санхүүгийн

тайлангийн “Толилуулга” батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул аудитын явцад залрууллаа.Үүнд:

1. Баацагаан сумын ХХС нь 106.6 сая төгрөгийн хувь хүмүүст олгосон зээлийг гадаад зээлээс дамжуулан зээлдүүлсэн зээлийн авлага гэж бүртгэсэн.
2. Бөмбөгөр сумын ЗДТГ-ын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 30.0 сая төгрөгийн автомашиныг данснаас хасахдаа худалсан ангиллаар бүртгэсэн.
3. Баянхонгор аймгийн Үйлдвэржилт хөгжлийн корпораци ХХК нь хувь хүмүүст олгосон хөнгөлөлттэй зээлийн нийт 1,148.6 сая төгрөгийн авлагын насжилтыг бүртгэхдээ нийт дүнгээр насжилт 2-3 жил дээр бүртгэснээс 366.0 сая төгрөгийн зээлийн насжилтыг буруу бүртгэсэн.
4. Байгал орчны газрын шилжүүлсэн 29.0 сая төгрөгийн хөрөнгийг бүтцийн өөрчлөлтөөр шилжүүлсэн ангиллаар бүртгэсэн.

Аудитаар нийт 4 алдаа, зөрчил илрүүлж зөрчлийг таслан зогсоох 3 албан шаардлага, зөрчлийг давтан гаргахгүй 1 зөвлөмжийг хүргүүллээ.

Баянхонгор аймгийн ТЕЗ болон харьяа байгууллагуудын нийт илрүүлсэн 1,400.7 сая төгрөгийн санхүүгийн залруулагдаагүй материаллаг зөрчил нь бидний тогтоосон 3,159.7 сая төгрөгийн материаллаг байдлын түвшнээс бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

5.1. Албан шаардлага

5.1.1.“Баян өсөх агро” ОНӨААТҮГ нь 2025 оны санхүүгийн тайлангийн аудитаар “Сөрөг” дүгнэлт авсан, тайлант онд худалдан авч зарцуулсан бараа материал баримтаар нотлогдоогүй, 17.4 сая төгрөгийн авлага, 252.3 сая төгрөгийн өр төлбөртэй, аймгийн ОНХС болон жилийн хөгжлийн төлөвлөгөө хэрэгжүүлэх зардлаас олгосон 150.0 сая төгрөгийн үр нөлөө гараагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, 14 дүгээр зүйлийн 14.2.10-т “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: 1. Тус байгууллагын хөрөнгийг тоолж, авлага, өр төлбөрт дотоод хяналт, шалгалт хийж орон нутгийн төсвөөс олгосон хөрөнгийн үр дүнг тооцож зөрчлийг арилгах албан шаардлагыг аймгийн Засаг даргад хүргүүлэв.

5.1.2.“Хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн кластер байгуулах” төслийн хүрээнд бий болсон 10 (арав) авто машиныг Үйлдвэржилт хөгжлийн корпорацийн хөрөнгөд бүртгэсэн боловч тээврийн хэрэгслийн гэрчилгээг шилжүүлээгүй, ингэний сүүний үйлдвэр, ингэний фермийн тоног төхөөрөмжийг аймгийн ЗДТГ-ын хөрөнгөд бүртгэсэн боловч тоног төхөөрөмжүүдийг ашиглаагүй олон газарт хуваан байршуулсан, хариуцах албан тушаалтан тодорхойгүй зэрэг нь төслийн хүрээнд бий болсон хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт хангалтгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.10-т “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх”, 41 дүгээр зүйлийн 41.2.7-д “Хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.5-д “орон нутгийн өмчийн эд хөрөнгийн нэгдсэн бүртгэл хөтлөх, эд хөрөнгийн тооллого явуулах ажлыг зохион байгуулах” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтыг журмын дагуу хэрэгжүүлж, зөрчлийг арилгах албан шаардлагыг аймгийн Засаг даргад хүргүүлэв.

5.1.3. Орон нутгийн өмчийн газраас тээврийн хэрэгслийг ашиглалт, хамгаалалтад тавих хяналт хангалгүйгээс элэгдлээрээ өртгөө нөхсөн ашиглах боломжгүй болсон авто тээврийн хэрэгслийг актлах, балансаас балансад шилжүүлэхдээ холбогдох хяналт хэрэгжүүлдэггүй, шинээр бий болсон тээврийн хэрэгслийг эзэмшигч байгууллага

бүртгээгүй, гэрчилгээг шилжүүлээгүй зэрэг зөрчлүүд илэрч аудитын судалгаагаар тээврийн хэрэгслээ үзлэгт оруулаагүй орон нутгийн төсвийн 32 тээврийн хэрэгсэл байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2-т “Төрийн байгууллага, албан газар төрийн болон орон нутгийн өмчит төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлэг нь өөрт олгогдсон эд хөрөнгийн талаар дараах эрх, үүрэгтэй”, 14.2.1-т “өөрт олгогдсон эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн зориулалтын дагуу эзэмшиж, ашиглах” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Орон нутгийн өмчит байгууллагуудын тээврийн хэрэгслийн ашиглалт, хадгалалтад хяналт хэрэгжүүлэх албан шаардлагыг ОНӨГ-т хүргүүлэв.

5.2. Зөвлөмж

5.2.1. Бүтэц орон тоотой холбоотой.

Илрүүлэлт: Аймгийн ЗДТГ-ын даргын 2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн “Байгууллагын 2026 оны бүтэц орон тоо, цалингийн санг шинэчлэн тогтоох тухай” А/01 дүгээр тушаалаар орон тооны зөвлөх 1 баталсан ба аймгийн Засаг даргын 2025.06.02-ны өдрийн Б/39 дүгээр тушаалаар 1 зөвлөхийг нэмж томилсон байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4-т “Энэ хуульд заасныг зөрчиж тэргүүн дэд, дэд, орлогч дарга, зөвлөхийн чиг үүрэгтэй ижил эрх, үүрэг бүхий өөр нэршилтэй албан тушаалын орон тоо бий болгох, түүнд аливаа албан тушаалтныг томилох, орон тоог хэвээр хадгалахыг хориглоно” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн хэмнэлтийн хуулийг хэрэгжүүлж ажиллах зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлэв.

Зөвлөмж хэрэгжүүлэх хугацааг 2026 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн дотор, албан шаардлагын биелэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 09 дүгээр сарын 25-ны дотор, холбогдох баримтын хамт ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/сая төгрөгөөр/			
							Үүнээс		Залруулаагүй	Залруулсан
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
Баацагаан сумын ХХС нь 106.6 сая төгрөгийн хувь хүмүүст олгосон зээлийг гадаад зээлээс дамжуулан зээлдүүлсэн зээлийн авлага гэж бүртгэсэн.	1	106.6			1	106.6	1	106.6		
Бөмбөгөр сумын ЗДТГ-ын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 30.0 сая төгрөгийн автомашиныг данснаас хасахдаа худалсан ангиллаар бүртгэсэн.	1	30.0			1	30.0	1	30.0		
Баянхонгор аймгийн Үйлдвэржилт хөгжлийн корпораци ХХК нь хувь хүмүүст олгосон хөнгөлөлттэй зээлийн нийт 1,148.6 сая төгрөгийн авлагын насжилтыг бүртгэхдээ нийт дүнгээр	1	366.0			1	366.0	1	366.0		

нажилт 2-3 жил дээр бүртгэснээс 366.0 сая төгрөгийн зээлийн насжилтыг буруу бүртгэсэн.									
Байгаль орчны газрын шилжүүлсэн 29.0 сая төгрөгийн хөрөнгийг бүтцийн өөрчлөлтөөр шилжүүлсэн ангиллаар бүртгэсэн.	1	29.0			1	29.0	1	29.0	
Нийт дүн	4	531.6			4	531.6	4	531.6	

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
"Баян өсөх агро" ОНӨААТҮГ нь 2025 оны санхүүгийн тайлангийн аудитаар "Сөрөг" дүгнэлт авсан, тайлант онд худалдан авч зарцуулсан бараа материал баримтаар нотлогдоогүй, 17.4 сая төгрөгийн авлага, 252.3 сая төгрөгийн өр төлбөртэй, аймгийн ОНХС болон жилийн хөгжлийн төлөвлөгөө хэрэгжүүлэх зардлаас олгосон 150.0 сая төгрөгийн үр нөлөө гараагүй байна.	1	-	-	-	1	-	-	-
"Хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн кластер байгуулах" төслийн хүрээнд бий болсон 10 (арав) авто машиныг Үйлдвэржилт хөгжлийн корпорацийн хөрөнгөд бүртгэсэн боловч тээврийн хэрэгслийн гэрчилгээг шилжүүлээгүй, ингэний сүүний үйлдвэр, ингэний фермийн тоног төхөөрөмжийг аймгийн ЗДТГ-ын хөрөнгөд бүртгэсэн боловч тоног төхөөрөмжүүдийг ашиглаагүй олон газарт хуваан байршуулсан, хариуцах албан тушаалтан тодорхойгүй зэрэг нь төслийн хүрээнд бий болсон хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт байна.	1	-	--		1	-	-	-
Орон нутгийн өмчийн газраас тээврийн хэрэгслийг ашиглалт, хамгаалалтад тавих хяналт хангалгүйгээс элэгдлээрээ өртгөө нөхсөн ашиглах боломжгүй болсон авто тээврийн хэрэгслийг актлах, балансаас балансад шилжүүлэхдээ холбогдох хяналт хэрэгжүүлдэггүй, шинээр бий болсон тээврийн хэрэгслийг эзэмшигч байгууллага бүртгээгүй, гэрчилгээг шилжүүлээгүй зэрэг зөрчлүүд илэрч аудитын судалгаагаар тээврийн хэрэгслээ үзлэгт оруулаагүй орон нутгийн төсвийн 32 тээврийн хэрэгсэл байна.	1	-	-	-	1	-	--	
Аймгийн ЗДТГ-ын даргын 2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн "Байгууллагын 2026 оны бүтэц орон тоо, цалингийн санг шинэчлэн тогтоох тухай" А/01 дүгээр тушаалаар орон тооны зөвлөх 1 баталсан ба аймгийн Засаг даргын 2025.06.02-ны өдрийн Б/39 дүгээр тушаалаар 1 зөвлөхийг нэмж томилсон байна.	1	-	-	-			1	-
Дүн	4	-	-	-	3	-	1	-

оОо